

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

ИЛТГЭХ ХУУДАС

Захирагчийн харьяа байгууллагуудын өмч, эд хөрөнгөд хяналтын үзлэг тооллого явуулсан тухай

2016 оны 05 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Хотын Ерөнхий менежерийн 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулагдсан Өмч, эд хөрөнгийн үзлэг, тооллогын явцад хяналт тавьж ажиллах Комисс 2016 оны 05 дүгээр сарын 02-20-ны өдрүүдэд уг ажлыг зохион байгууллаа.

Хяналтын комиссоос Захирагчийн ажлын албаны харьяа газруудын 2015 оны хөрөнгийн тооллогын дүн мэдээтэй танилцаж, өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын үйл ажиллагаа болон нийтийн эзэмшлийн байгууламж, бусад хөрөнгийг тооллогод бүрэн хамруулсан байдалд хяналт тавьж, тооллогын явцад тооллогын бүртгэлд гарсан алдаа дутагдал, зөрчлийг арилгуулах асуудлаар хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох маягтыг бүрдүүлэх ажлыг гүйцэтгүүлж /Маягт ТӨ 9-12 болон бусад/, тайлан мэдээнд тусгуулах чиглэлээр зөвлөмж чиглэл өгч гүйцэтгэлийг хангуулж ажилласан.

Тооллогын явцад залруулах боломжгүй /цаг хугацаа болон эрх зүйн хувьд/ асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгуулах асуудлаар тооллогын тайлан мэдээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналд тусгуулсан.

Захирагчийн ажлын албаны харьяа 8 байгууллага тус бүр даргын шийдвэрээр “Тооллогын комисс”-ыг байгуулж, тогтоосон хугацаанд үзлэг тооллогыг явуулсан ба биет хөрөнгийг нүдээр үзэж тоолсон байна.

Хяналтын ажлын хэсгээс батлагдсан удирдамжийн дагуу харьяа газруудын өмч хөрөнгөд түүвэрчилсэн хэлбэрээр үзлэг тооллого явуулж, тухайн хөрөнгийн бүртгэлд гарсан алдаа дутагдлыг засуулах, цаашид НӨХГ-т хандаж шийдвэрлүүлэх асуудлуудыг тодорхойлж, санал дүгнэлт боловсруулж ажиллалаа.

1."УЛААНБААТАР ЛИФТ" НӨҮГ.

Тус байгууллагад Хяналтын ажлын хэсгийн гишүүн Б.Гэрэл, З.Мөнгөнзул, НӨХГ-ын мэргэжилтэн н.Гэрэлтуяа нар 05 дугаар сарын 06-нд ажилласан.

Байгууллагын даргын 2016 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан тооллогын комиссын ажилд Хяналт тавих ажлын явцад маягтыг зөв бурууг бүртгэл дээр тулгаж, авто машин, техникийн бүртгэл, агуулахыг нягтлан шалгалаа.

Хяналтын ажлын чиглэл: “Барилга байгууламж”, “Тээврийн хэрэгсэл”, “Сэлбэг, агуулахын бараа материал”

Тооллогын ажлыг зохион байгуулах комисс эд хөрөнгийг бүртгэлд оруулахдаа буруу нэршил хэрэглэх, буруу кодоор тэмдэглэх зэрэг алдаа байсныг тайлбарлаж, хийх аргачлалын талаар зөвлөгөө өгсөн.

1.Барилга байгууламжын бүртгэл тооллогын асуудал.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Намьянжугийн гудамж, 13 дугаар хорооллын 15 дугаар хорооны “Өрхийн эмнэлэг”-ийн байрыг 2012 оны 11-р сарын 02-ны өдрийн НИТХТ 49-р тогтоолоор 62,748,000 төгрөгийн үнэ бүхий барилга байгууламж, мөн газрыг балансаас балансад шилжүүлсэн боловч байгууллагын нэр дээр газрын гэрчилгээгээ гаргуулаагүй байна. Мөн газрын эзэмшил дээр баригдсан “Хашаа”-г өөрийн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байсныг илрүүлж, бүртгэлд тусгуулах, “Бүртгэлгүй хөрөнгийн маягт”-ыг /Маягт ТӨ 9/ бөглөх асуудлаар комисст зөвлөмж өгсөн.

2.Тээврийн хэрэгслэлийн бүртгэл, ашиглалтын асуудал.

Тээврийн хэрэгслийн 2015 оны бүртгэлд 198,2 сая төгрөгийн өртөг бүхий нийт 4 тээврийн хэрэгсэл бүртгэгджээ. Үүнд: Крантай буюу хагас ачигч 1, суудлын авто машин 3 байна. Эдгээр тээврийн хэрэгслээс 1 нь тээврийн хэрэгслийг зөөвөрлөх зориулалтаар, 3 нь албаны зориулалтаар ашиглагдаж байна. Тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэг бүрчлэн нягталж, газар дээр нь тулгалт хийж, шалгасан бөгөөд тээврийн хэрэгслийн моторын дугаарууд паспорт, бичиг баримтын бүртгэлд бүрэн зөв тусгагдсан байсан.

Тээврийн хэрэгсэл зөөвөрлөх зориулалттай 1 авто машиныг ажилд гардаггүй гэсэн шалтгаанаар 2016 оны татварыг төлөөгүй байсан ба нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан тээврийн хэрэгслийн ашиглалт хангалтгүй байна.

Ажлын хэсгээс тээврийн хэрэгслийн хувийн хэрэгт засвар үйлчилгээний мэдээллийг тогтмол хөтлөх шаардлагатай талаар зөвлөсөн.

3. Агуулахын сэлбэг бараа материалын бүртгэлийн асуудал.

Хувь хүний эзэмшлийн агуулах, гражыг түрээсэлдэг бөгөөд агуулах нь Баянзүрх дүүргийн 14 дүгээр Хороо, граж нь Хан-Уул дүүргийн 2 дугаар Хороонд байрладаг байна.

Агуулахад байгаа эд хөрөнгө буюу багаж, хангамжийн материалын ашиглалт, агуулахын бүртгэл, зарцуулалт хэвийн байна. Хадгалалтын хувьд эмх замбараагүй байсныг цэгцлэх асуудлаар зөвлөсөн.

Цаашид авах арга хэмжээ: Улаанбаатар лифт НӨҮГ-т.

1. Балансаас балансад шилжиж ирсэн БЗД-ийн 15 дугаар хорооны “Өрхийн эмнэлэг”-ийн газрын гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулах, улмаар холбогдох маягтыг үйлдэж, үндсэн хөрөнгөд бүртгүүлэх.
2. Дээрх газрын хашааг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх.
3. Тээврийн хэрэгслийн хувийн хэрэгт засвар үйлчилгээний мэдээллийг тогтмол хөтөлж байх.

НӨХГ-т хүргүүлэх санал:

1. Газрын гэрчилгээг үндэслэж, байгууллагын хөрөнгөд бүртгэх.

2.ШУУРХАЙ УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ.

Тус байгууллагад Хяналтын ажлын хэсгийн гишүүн Оюунтөгс, Б.Гэрэл, НӨХГ-ын мэргэжилтэн Энхбаяр нар 05 дугаар сарын 06, 12-нд ажилласан.

2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Хяналтын комисс Төвийн өмч, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын байдалтай танилцахад үндсэн хөрөнгийн тооллогын маягтын бүрдлийг бүрэн бүрдүүлсэн хэдий ч эмх замбараагүй, эд хөрөнгийн нэршлийг төрлөөр ангилж, ялгаагүй байсныг залруулах зөвлөмж чиглэл өгч гүйцэтгэлийг хангуулсан.

- Машин, тоног төхөөрөмжийн бүртгэл /Маягт-5/
- Тээврийн хэрэгслийн бүртгэл /Маягт-6/
- Тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл /Маягт-7/
- Биет бус хөрөнгийн бүртгэл /Маягт ТӨ-3/-д бүртгэжээ.

Хяналтын ажлын чиглэл: “Хяналтын камер”

Төвийн Үндсэн хөрөнгийн тооллогын маягт /Маягт 3, 5/-ын бүрдэл хангалтгүй, өмчийн нэршил гүйцэт бус, зориулалт марк, үзүүлэлтийг тодорхой тусгаж бүртгэлжүүлээгүй дутагдалтай байсан тул 2016 оны 05 дугаар сарын 13-ны дотор үндсэн хөрөнгийн тооллогын маягтыг нэг бүрчлэн засварлаж, дахин шинэчлэх зөвлөмж өгч ажилласан.

“Хяналтын камер”.

Төвийн үйл ажиллагаанд чиглэлийн болон эргэдэг 2 төрлийн **нийт 42 хяналтын** камерыг нийтийн эзэмшлийн зам талбай, төвлөрсөн хогийн цэг, зөөврийн хяналтын зориулалтаар ашиглаж байна. Үүнээс 39 хяналтын камер нь Үндсэн хөрөнгийн тооллогын маягтад бүртгэлтэй байна. Хяналтын камеруудын ажиллагаа хэвийн байна.

Цаашид авах арга хэмжээ. ШУЗТ-д

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй хяналтын 3 камерыг “Бүртгэлгүй хөрөнгийн маягт” Маягт ТӨ9-ыг хөтөлж, бүртгэлд тусгуулах.

3.ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ НӨҮГ.

Тус байгууллагад Хяналтын ажлын хэсгийн гишүүн С.Аригуун, Т.Оюунтөгс, Гэрэлтуяа нар 05 дугаар сарын 06-нд ажилласан.

Хяналтын ажлын чиглэл: “Автомашин”, “Шилэн кабель”.

Авто замын хяналтын камерын шилэн кабель болон тээврийн хэрэгсэл зөөж, шилжүүлэх зориулалттай авто машины бүртгэл, ашиглалттай танилцаж, шалгалаа.

Автомашин:

Төвийн тээврийн хэрэгслийн 2015 оны бүртгэлд нийт 16 тээврийн хэрэгсэл бүртгэгджээ. Үүнд бүтэн ачигч 3, крантай буюу хагас ачигч 3, задгай чирэгч 6, суудлын авто машин 1, ачааны авто машин 1, нийтийн тээврийн том оврын автобус чирэхэд зориулагдсан тусгай зориулалтын 2 авто машин тус тус байна.

Дээрх тусгай зориулалтын 2 авто машиныг НЗД-ын 2016 оны А/302 дугаартай захирамжаар балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлээс хасч, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т өгчээ. Эдгээр тээврийн хэрэгслээс нийт 12 нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх зориулалтаар, 2 нь албаны зориулалтаар ашиглагдаж байна.

Төв нь дээрх 12 тээврийн хэрэгслийг НӨХГ-ын даргын 2013 оны А/429 дүгээр тушаалаар данс бүртгэлдээ бүртгэн авсан байна. эдгээр 12 тээврийн хэрэгслэлийн үнэ нь холбогдох баримт бичгүүдэд зөрүүтэй тусгагдсаныг залруулах зөвлөмж чиглэл өгсөн. “Хьюндай моторс Монгол” ХХК-иас тээврийн хэрэгсэл хүлээн авсан актан дээрх үнээс зөрүүтэй байсан.

НӨХГ-ын даргын тушаалын хавсралтад тусгагдсан үнэ, ЗХУТөвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн үнэ зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэг бүрчлэн нягталж, тулгалт хийж, шалгасан бөгөөд тээврийн хэрэгслийн зарим гэрчилгээ болон машин, тоног төхөөрөмжийн бүртгэлд хөдөлгүүрийн дугаарууд бичигдээгүй байсан тул тоног төхөөрөмжийн бүртгэлд нөхөн, бичилт хийлгэх арга хэмжээг авч, гэрчилгээн дээр бичүүлэх, бүртгүүлэх асуудлаар зөвлөмж өгсөн.

Шилэн кабелийн бүртгэл:

Төв нь Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ний худаг, сувагчлалыг түрээслэдэг бөгөөд ашиглаж буй шилэн кабелийн урт нийт 72,050 м, үүнээс Төвийн өмч, эд хөрөнгөд бүртгэлтэй нийт 50,500 м, **бүртгэлгүй 21,550 м** шилэн кабель байгаа бөгөөд шилэн кабелийн ашиглалт хэвийн ажиллаж байна.

Бүртгэлтгүй шилэн кабелийг Бүртгэлд тусгагдаагүй маягтыг хөтөлж /Маягт ТӨ-9/, цаашид тус Төвийн өмч, эд хөрөнгийн бүртгэлд бүртгэх шаардлагатай бөгөөд тус төвийн шилэн кабель нь Үндсэн хөрөнгийн тооллогын маягтад Машин тоног төхөөрөмжийн бүртгэл /Маягт-5/-д бүртгэлтэй байна. Шилэн кабель нь холбооны шугам сүлжээ бөгөөд Барилга байгууламжийн бүртгэл /Маягт-3/-д бүртгэгдэх өмч тул маягтын дагуу шилжүүлэх нь зүйтэй гэж Хяналтын комиссын зүгээс үзлээ.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ. ЗХУТ.

1. Бүртгэлтгүй 21,550м шилэн кабелийг “Бүртгэлгүй хөрөнгийн маягт” /Маягт ТӨ9/-ыг хөтөлж үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгуулах.

НӨХГ-т хүргүүлэх, шийдвэрлүүлэх ажлын санал:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2013 оны А/429 дүгээр тушаалын хавсралтыг сольж үнийн дүнг зөв болгох, бүртгэлд тусгуулах.

4. МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨААТҮГ.

Тус байгууллагад Хяналтын ажлын хэсгийн гишүүн Бя.Эрдэнэбат, Д.Булган, Б.Гэрэл, н.Энхбаяр нар 05 дугаар сарын 11-нд ажилласан.

Хяналтын ажлын чиглэл: “Барилга байгууламж”, “Газар”, “Авто машин, техникийн бүртгэл”, “Агуулахын сэлбэг бараа материалын бүртгэл”, “Тоног төхөөрөмжийн бүртгэл”.

Тус байгууллагын даргын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/13 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулагдан ажиллаж байна. Тооллогын ажлыг зохион байгуулах комисс эд хөрөнгийг бүртгэлд оруулахдаа эд хөрөнгийн нэр төрөл, нэршил, ангиллын кодыг буруу тэмдэглэж, хангамжийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэлжүүлсэн байсныг залруулах, асуудлаар зөвлөмж өгч зөрчлийг арилгуулсан.

1.Барилга байгууламж, газрын бүртгэл.

Гудамж төслийн хүрээнд Чингис бондоор 2013 онд 12,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 8,5км зам, А,Б тойрог, автомашины зогсоол зэрэг байгууламж хийгдсэн бөгөөд Улсын комисс одоог хүртэл хүлээж аваагүй, улмаар тус байгууллагын болон нийслэлийн өмчид бүртгэгдээгүй байна.

Мөн Нийслэлийн хөрөнгөөр 14,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Тухайлбал: 343,9 сая.төгрөгийн үнэ бүхий оффисын барилга, 39,8 сая.төгрөгийн үнэ бүхий гүний худаг, амралт цогцолбор, бусад өмч хөрөнгө бүртгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 456 дугаар тогтоолоор Үндэсний их баяр наадмын Монгол наадам цогцолборт зориулан нийт 12,582га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авч хилийн цэсийг тогтоон баталсан боловч газрын гэрчилгээ бичиг баримтгүй байна. Эдгээр газар нь Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт 551га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт Монгол наадам цогцолборын Морь барианы 12031га газрууд хамаарч байдаг.

Дээрх газруудад гэрчилгээ байхгүй байсан тул байгууллагын нэр дээр газрын гэрчилгээг гаргуулах шаардлагатай гэж үзсэн.

2.Тээврийн хэрэгслийн бүртгэл.

Тээврийн хэрэгслийн 2015 оны бүртгэлд 1,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий нийт 26 тээврийн хэрэгсэл бүртгэгджээ. Үүнд: Цэвэр усны машин /DONGFENG/-1, бохирын машин/DONGFENG/-1, хогийн машин /ISUZU/-1, ачааны /DONGFENG/-1, трактор /BOBCAT/-1, цэвэр усны /DONGFENG/-1, суудлын машин / STAREX /-1, суудлын машин / ELENTRA /-1, мотоцикл/ MUSTANG/-1, эко автобус /Экологи бус/-15.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэг бүрчлэн нягталж, үзлэг тооллого явуулсан бөгөөд тээврийн хэрэгслийн моторын дугаарууд паспорт, бичиг баримтын бүртгэлд бүрэн зөв тусгагдсан байсан бол 15ш “Эко автобус”-ыг замын хөдөлгөөнд оролцохгүй, техникийн үзлэгт ордоггүй гэсэн тайлбартайгаар улсын дугаар олгогдоогүй байна.

Тээврийн хэрэгслийн хувийн хэрэгт засвар үйлчилгээний мэдээллийг тогтмол хөтөлж байсан хэдий ч эко автобусын засвар үйлчилгээг хувийн хэрэгт хөтлөх асуудал хангалтгүй байсныг анхаарч ажиллах талаар зөвлөмж өгсөн.

3. Агуулахын сэлбэг бараа материалын бүртгэлийн асуудал.

Нийт 1,2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 2ш агуулахын барилга бүртгэгджээ. Агуулахад байгаа эд хөрөнгө буюу багаж, хангамжийн материалын ашиглалт хэвийн бөгөөд агуулахын бүртгэл, зарцуулалт хэвийн, хадгалалтын хувьд эмх замбараатай байсан. Нийтийн бие засах газар зуны 22ш, өвлийн зориулалттай 7ш нийт 758,7 сая.төгрөгийн үнэ бүхий 29ш НБЗГ-ыг ашигладаг бөгөөд тухайн хөрөнгийн ашиглалтыг хянах боломжгүй байсан. Зуны зориулалттай бие засах газрын бохирыг хөлдөөхгүй, хэвийн зохистой хэмжээнд ашиглаж, тэдгээрт хувийн хэрэг, тэмдэглэл хөтөлж байх асуудлаар зөвлөмж өгсөн.

4. Тоног төхөөрөмжийн бүртгэлийн асуудал.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн Сийлбэртэй 10 ханатай гэр, 5 ханатай 12 ш монгол гэр бүртгэгдсэн байна. /Балансын нийт үнэ 120940000/ ашиглалт хэвийн бөгөөд хадгалалтын хувьд эмх замбараатай байсан. Гэрийн доторхи тавилгуудыг нэг бүрчлэн тооллогын бүртгэлд бүртгээгүй, /гэр нь анх иж бүрнээр нийлүүлэгдсэн/, Караокений тоног төхөөрөмж тооллогын бүртгэлд тусгаагүй байсныг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх асуудлаар зөвлөмж өгсөн.

Цаашид авах арга хэмжээ: Монгол наадам цогцолборт.

1. Улсын тусгай хэрэгцээнд авч хилийн цэсийг тогтоож өгсөн тус байгууламжийн газарт “Газрын гэрчилгээ” гаргуулах.
2. Бие засах газар тус бүр дээр хувийн хэрэг хөтлөх,
3. Гэрийн тавилгуудыг тус бүрээр үндсэн хөрөнгөд бүртгэх, бүртгэлгүй хөрөнгийн маягт /Маягт ТӨ9/-ыг хөтлөх.
4. Караокений тоног төхөөрөмжийг мөн үндсэн хөрөнгөд бүртгүүлэх

НӨХГ-т хүргүүлэх, шийдвэрлүүлэх ажлын санал:

1. Гудамж төслийн хүрээнд Чингис бондын хөрөнгөөр хийгдсэн 8,5км зам, А,Б тойрог, авто машины зогсоол зэрэг 12,1 тэрбум төгрөгийн хөрөнгийг нийслэлийн хөрөнгөд бүртгэж авах эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх.

2. УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР.

Тус газарт комиссын гишүүн Ц.Рэгзэдмаа, Б.Эрдэнэбат, Л.Алтангэрэл, НӨХГ-ын мэргэжилтэн Б.Оюунсүрэн, н.Долгормаа нар 2016 оны 5 дугаар сарын 5,19,23,24-ний өдрүүдэд ажиллалаа.

Ажлын чиглэл: Газрын балансад бүртгэлтэй барилга байгууламжийн эзэмшил газар, Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хамаарах газар, уг газруудын бүртгэл, эзэмшилт, ашиглалт, хамгаалалт, эзэмшүүлэх, ашиглуулах

УСУГ нь нийт 1100 барилга байгууламж, 594 байршил дахь газар зэрэг нийт 250,0 гаруй тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө бүртгэгдсэн байна.

Мөн тооллогын ажлын явцад анхаарах асуудлаар, тухайлбал тайланд хавсаргах баримт бичгийн иж бүрдэл, хөрөнгийн ангиллын код, тоног төхөөрөмжийн хүчин чадал, марк, биет хэмжээг зөв сонгосон эсэх, илтгэх хуудсанд шаардлагатай тодруулга, тайлбар бичих, илүүдэлтэй ба ашиглалтгүй хөрөнгийн талаар тодорхой бичих, бүртгэлгүй хөрөнгийг үнэлж оруулах, хөрөнгө данснаас хасахад бүрдүүлдэг баримт материал болон эзэмшиж буй газрын кадастр, гэрээ, гэрчилгээг хавсаргах, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл, хандив тусламжаар бий болсон хөрөнгүүдийн бүртгэлийг холбогдох маягтуудад үнэн зөв, бүрэн гүйцэд тусгах талаар заавар зөвлөгөө өгсөн болно.

Барилгын байгууламжийн эзэмшил газрын бүртгэлийн талаар:

- Байгууллагын эзэмшиж/ашиглаж буй газрын бүртгэл /Маягт-2/-т 594 байршил дахь газрын мэдээллийг оруулсан.
- Цэвэр усны түгээх шугам дээр баригдсан 341 Ус түгээх байр /Г24-Г364/-ны газрыг кадастрын мэдээллийн санд оруулж, нэгж талбарын дугаар авсан. Газрын төлбөрийн асуудал шийдэгдээгүй учир баталгаажилт хийлгээгүй, өөрөөр хэлбэл газар эзэмших шийдвэр гаргуулж, гэрээ байгуулаагүй байна.
- 40 Ус түгээх байрны газрын кадастрын зурагт нэгж талбарын дугаар аваагүй. Нэгж талбарын дугаар авах хүсэлтээ НӨХГ-т хүргүүлсэн байна.
- Айлын газрын кадастртай давхацсан объектуудын дахин төлөвлөлтийн асуудлыг тодруулах шаардлагатай байна.

Ундны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хамаарах газрын бүртгэл, ашиглалт, хамгаалалтын талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 50 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоосон байна. Өмнө нь Нийслэлийн Засаг даргын 2009 оны “Нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн газрын доорхи усны эх үүсвэрүүдийн тэжээлийн гадаад, дотоод мужийн хамгаалалтын бүсийн гадаад, дотоод мужийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 95 дугаар захирамжийг мөрдөж байсан.

Төвлөрсөн ус хангамжийн тэжээлийн дотоод мужид усан хангамжийн барилга байгууламжаас бусад барилга байгууламж ашиглахыг хориглодог.

Дотоод мужид зөвхөн голын эрэг орчмыг ойжуулах, усны нөөц, чанарын байдал, байгалийн төрх байдал, ус хөрс, амьтан ургамлын онцлог, тэдгээрийн хувьсал өөрчлөлттэй холбогдсон ажиглалт, судалгаа шинжилгээ явуулахдаа байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрийг ашиглахыг, гадаад дэглэмийн мужид инженерийн шугам сүлжээнд холбогдсон ахуйн зориулалттай барилга байгууламж, аялал жуулчлал, амралт зугаалга, уламжлалт мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрдөг байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар **төвлөрсөн ус хангамжийн тэжээлийн дотоод мужид** 300 гаруй нэгж талбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллага ногоо тарих, мод үржүүлэг, амралт сувилал, зуслан, үйлдвэрлэл үйлчилгээ, аж ахуйн чиглэлээр газар эзэмшиж байна. Тухайлбал: Баянзүрх дүүрэгт 3.423.617 м2 газар эзэмших зөвшөөрөлтөй 134 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 3.256.182 м2 газар нь ус хангамжийн тэжээлийн дотоод мужид багтсан байна.

Төвийн эх үүсвэрт байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨААТҮГ-ын хашаанд иргэдийн амарч зугаалах зориулалттай талбайгаас гадна аж ахуйн нэгж байгууллага, иргэд тус байгууллагатай гэрээ байгуулан төрөл бүрийн үйл ажиллагаа эрхлэх байдал ихсэх хандлагатай боллоо. Тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, барилга байгууламжийн инженерийн хангамж тодорхойгүй, төлөвлөгдөж батлагдаагүй байгаа нь Улаанбаатар хотын ундны усны хангамжийн гол эх үүсвэрийг бохирдуулах нөхцлийг үүсгэж болзошгүй юм.

Үйлдвэр болон Мах комбинатын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд ШШБЕГ-ын урьдчилан хорих төв, орон сууцны Ирээдүй хороолол, ногоо тарих, мод үржүүлгийн чиглэлийн аж ахуйн нэгж байгууллага, барилгын болон бусад хог хаягдал ихээхэн хэмжээтэй байна.

Дээд эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд Налайх дүүрэг болон Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нарын олгосон газар дээр амралт сувилал, ногоо тарих, мод үржүүлэг, зуслангийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд зөвшөөрөл, шийдвэргүйгээр газрыг ашиглаж байна. Энэ нь олон жил нутаглаж, мал маллаж ирсэн нутгийн иргэд байна.

Гачуурт, Төв, Дээд эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн хэмжээ нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 50 тоот тогтоолоор өмнөхөөс эрс багассан байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ: ОСНААУГ-т хүргүүлэх санал:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 50 тоот тогтоолын дагуу хотын хэмжээнд ус хангамжийн тэжээлийн мужид байгаа газар эзэмших иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Ус сувгийн удирдах газар хамтран гаргах,
2. Дээд эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн асуудлаар Төв, Хэнтий аймгийн Засаг дарга нартай зөвшилцөх уулзалтыг зохион байгуулж тодорхой шийдэлд хүрэх арга хэмжээг авах
3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд байрлах иргэн, аж ахуйн нэгжийн шинэчилсэн судалгааг хийх шаардлагатай байна.
4. Зөөврийн болон шугамын ус түгээх байруудын 200 м²-с бага талбайтай хамгаалалтын бүсийг нэмэгдүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлэх
5. Зөөврийн болон шугамын ус түгээх байруудын хамгаалалтын бүсийг Кадастрын мэдээллийн санд бүрэн оруулж тусгуулах ажлыг зохион байгуулах

НӨХГ-т хүргүүлэх, шийдвэрлүүлэх ажлын санал:

1. Улаанбаатар хотын ундны усны ариун цэврийн хамгаалалтын бүс дотор зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй ААНБ, иргэний барилга байгууламж, хүнсний ногооны хүлэмжүүд, амралт, сувиллын газруудын зөвшөөрлийг Нийслэлийн Засаг дарга хүчингүй болгох, Нийслэлийн Өмчийн харилцааны газар татан буулгах, нүүлгэн шилжүүлэх
2. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн бүсийн дэглэм зөрчин хууль бусаар газар олголт хийсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцон газрын зөвшөөрлийг хүчингүй болгох.

6. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР.

Тус газарт комиссын гишүүн Ц.Рэгзэдмаа, Б.Эрдэнэбат, Л.Алтангэрэл, НӨХГ-ын мэргэжилтэн Б.Оюунсүрэн, н.Долгормаа нар 2016 оны 5 дугаар сарын 5, 12, 9, 25-ний өдрүүдэд ажиллалаа.

Ажлын чиглэл: Ус дулаан дамжуулах төв /УДДТ/-ийн барилга байгууламж. /Барилгын паспорт, газрын гэрчилгээ, кадастрын зураг, барилга байгууламжийн фото зураг/.

ОСНААУГ нь нийт 127,9 тэрбум төгрөгний үндсэн хөрөнгөтэйгээс барилга байгууламжийн бүртгэлд 30,9 тэрбум төгрөгний, тээврийн хэрэгсэлд 1,9 тэрбум төгрөгний ,

тоног төхөөрөмжид 93,2 тэрбум төгрөгний, бусад хөрөнгө 1,9 тэрбум төгрөгний хөрөнгө бүртгэгдсэн байна.

Дараах асуудлуудыг НӨХГ-т уламжлан шийдвэрлүүлж өгөх талаар ОСНААУГ-ын тооллогын комисс хяналтын тооллогын ажлын хэсэгт санал тавилаа. Үүнд:

1.Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дангийн шар байруудад /Одоогоор Богд Ар хороолол баригдсан байршил/ гадна халаалт, цэвэр, бохир ус түгээж байсан 3559 метр урттай 208,7 сая төгрөгний өртөг бүхий шугамууд нь ОСНААУГ-ын үндсэн хөрөнгөөс хасагдаагүй байдаг. Тухайн инженерийн шугам сүлжээг актлуулах.

2.Чингэлтэй дүүрэгт байрлах ХҮТ-7-ын уурын зуухны барилгыг 2002 онд Хот байгуулалт, барилга төлөвлөлтийн газраас “Барилга буулгуулах тухай” 2/376 дугаар албан тоот ОСНААУГ-т ирүүлсэнээр 2008 онд тухайн барилгын суурин дээр “Жигүүр гранд” ХХК орон сууцны 9 давхар барилга барьсан байна. 50,3 сая төгрөгний өртөг бүхий тухайн уурын зуухны барилгыг данснаас хасуулах асуудлаар НӨХГ-т танилцуулж, хүсэлт тавьж, албан бичиг хүргүүлж байсан боловч шийдэгдээгүй байна.

Хяналтын тооллогын ажлын хэсэг газрын гэрчилгээ, гэрээ байхгүй УДДТ-ийн жагсаалтыг гаргуулан авч танилцлаа.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ: ОСНААУГ-т хүргүүлэх санал:

1. Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу өмч хөрөнгийн бүртгэл мэдээллийг зааврын дагуу тооллогын маягтад зөв тусгах.
2. Газрын гэрчилгээ, гэрээ байхгүй 32 ширхэг “Ус дулаан дамжуулах төв”-ийн газрыг баталгаажуулан гэрчилгээжүүлэх, кадастр хийлгэх ажлыг зохион байгуулах.

НӨХГ-т хүргүүлэх, шийдвэрлүүлэх ажлын санал:

1. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дангийн шар байруудын /Одоогоор Богд Ар хороолол баригдсан байршил/ 208,7 сая төгрөгний төсөвт өртөгтэй 3,559 метр урттай гадна цэвэр бохир усны шугам сүлжээг актлах.
2. Чингэлтэй дүүрэгт байрлах 50,3 сая төгрөгний төсөвт өртөгтэй ХҮТ-7-ын уурын зуухны барилгыг ОСНААУГ-ын балансаас хасах.
3. ОСНААУГ-ын балансад тусгагдаагүй байгаа Азийн хөгжлийн зээлийн хөрөнгөөр баригдсан 19 ширхэг УДДТ-ийг нийслэлийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулах.

7.ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР

Тус байгууллагад 2016 оны 5 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Ц.Рэгээдмаа, Б.Эрдэнэбат, Л.Алтангэрэл, Б.Оюунсүрэн нар эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг явууллаа.

Ажлын чиглэл: “Халаалтын зуухны барилга байгууламж”, “Халаалтын зуух”-ны бүртгэл, ашиглалт.

Барилга байгууламжийн бүртгэлд нийт 2,7 тэрбум төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 38 барилга, байгууламж бүртгэлтэй байгаагаас 17 нь барилга, 3 нь саравч, контейнер, 9 нь шугам сүлжээ, 9 нь уурын зуухны хашаа байна.

Машин тоног төхөөрөмжийн бүртгэлд нийт 2,6 тэрбум төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 21 нэр төрлийн 37 ширхэг халаалтын зуух бүртгэгдсэн байна.

Хяналтын тооллогын явцад Биокомбинат, Шувуу, 79 дүгээр сургуулийн 1,2 дугаар байр, Глоб интернейшнлийн халаалтын тогоо болон 46 дугаар сургуулийн актлагдсан зууханд засвар үйлчилгээ хийсэн байдалтай газар дээр нь очиж танилцлаа.

Бүртгэгдсэн эд хөрөнгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар ашигладаггүй, дээд шатны байгууллагаас шийдвэр хүлээгдсэн болон орон нутгийн өмчийн бүртгэлд

бүртгэгдээгүй эд хөрөнгө, өмчийн маргаантай доорхи анхаарвал зохих асуудлууд байна. Үүнд:

- Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй нийт 283,5 сая.төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий **8 халаалтын зуухны 35 нэр төрлийн** барилга байгууламж, тоног төхөөрөмжийг “Ану сервис” ХХК ашиглаж байна. ХИХУГ-аас өмчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр НӨХГ-т 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдөр 1/119, 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/209, 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр 1/61, 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1/121 дугаар албан тоотуудыг холбогдох бичиг баримтын хамт явуулсан боловч одоог хүртэл шийдэгдээгүй байна.
- Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургуулийн бага сургуулийн хичээлийн байр, ажилчдын сууцыг халаах зориулалт бүхий халаалтын зуухны барилгад суурилагдсан **2 зуухны 1 зуухыг Ану сервис ХХК**, нөгөөг нь ХИХУГ хариуцан ажиллаж байна. Мөн тухайн уурын зуухны барилга нь бага сургуулийн барилгатай хамт баригдаж ашиглалт орсон гэх боловч аль газрын хөрөнгөнд бүртгэлтэй нь тодорхойгүй байна.
- Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр, Шувуун фабрикт 2014 онд шинээр баригдсан 1,8 тэрбум төгрөгний өртөгтэй 2.8 Гкал хүчин чадал бүхий халаалтын зуухны цогцолбор байгууламж нь ХИХУГ-ын хөрөнгөнд бүртгэлгүй байна. Зөвхөн газрын бүртгэл Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-т гэрчилгээтэй байна.
- Мянганы Сорилын сангийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн хүрээнд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын захиалгаар 2012-2013 онд Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо Амгалан, Улаанбаатар төмөр замын Төв засварын станцад халаалтын 2 тогоо суурилуулсан. Гэвч ашиглагч байгууллага болох Улаанбаатар төмөр зам нь Оросын холбооны улсад үйлдвэрлэгдсэн халаалтын тогоо тавих болсон тул дээрх 2 тогоог 2013 онд буулган Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч, үндсэн хөрөнгөнд бүртгэх ажлыг зохион байгуулахыг мэдэгдсэн боловч бүртгэлжүүлээгүй байна.
- Баянгол дүүргийн 46 дугаар сургуулийн халаалтанд ашиглагдаж байгаад зуухны актлагдсан, ашиглалтын хугацаа дууссан 2 халаалтын зуухыг дахин ашиглахаар Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ өөрийн хөрөнгөөр засварласан байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ: ХИХУГ-т хүргүүлэх санал:

1. Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу өмч хөрөнгийн бүртгэл мэдээллийг зааврын дагуу тооллогын маягтад зөв тусгах
2. Баянгол дүүргийн 46 дугаар сургуулиас актлагдсан 2 тогоог тус байгууллагын хөрөнгөд бүртгэж болох асуудлыг тодруулах, шийдвэрлүүлэх. Ашиглалтын шаардлага хангах эсэх асуудлаар Нийслэлийн Агаарын чанарын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ болон холбогдох мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах.

НӨХГ-т хүргүүлэх санал:

1. Мянганы Сорилын сангийн санхүүжилтээр хэрэгжсэн төслөөс буусан 2 тогооны үнэлгээг тогтоон Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулан “Бүртгэлгүй хөрөнгийн маягт”-д бүртгэж, бүртгэлжүүлэх, үндсэн хөрөнгөд тусгуулах.
2. “Ану-Сервис” ХХК-тай 2006 онд байгуулсан менежментийн гэрээг дүгнэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх, улмаар тус байгууллагын ашиглалтад байгаа 8 зуухыг хувьчлах, ХИХУГ-ийн бүртгэлд тусгах эсэх асуудлыг Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

3. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургуулийн бага сургуулийн байрыг дулаанаар хангадаг халаалтын 2 тогоог тус байгууллагад бүртгэлжүүлэх эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх.
4. Мөн тус сургуулийн бага сургуулийн уурын зуухны барилга, газар нь аль байгууллага дээр бүртгэлтэй болохыг тодруулж, эзэмшлийг тодорхой болгох.
5. Шувуун фабрикт баригдсан халаалтын зуухны цогцолбор байгууламжийг “Бүртгэлгүй хөрөнгийн маягт”-д тусгах, бүртгэлжүүлэх, ашиглагч байгууллагыг тодорхой болгох.

8.НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/298 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулагдсан Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаагаар ахлуулсан, мэргэжилтэн Б.Эрдэнэбат, мэргэжилтэн С.Аригуун, НӨХГ-ын Өмчийн хөдөлгөөн хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Б.Оюунсүрэн нарын бүрэлдхүүнтэй ажлын хэсэг 2016 оны 5 дугаар сарын 11,18, 23, 24-ний өдрүүдэд тус байгууллагад ажиллалаа.

Хяналтын ажлын чиглэл: “Барилга байгууламж”, “Авто машин”, “Далан суваг”, “Буу”.

Тус байгууллага нь захирлын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр “Тооллогын комисс байгуулах тухай” А/41 дүгээр тушаалаар 15 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулан ажилласан байна.

НҮУБН нь нийт 53,1 тэрбум төгрөгний үндсэн хөрөнгөтэйгээс барилга байгууламжийн бүртгэлд 3,7 тэрбум төгрөгний, тээврийн хэрэгсэлд 11,5 тэрбум төгрөгний, тоног төхөөрөмжид 2,2 тэрбум, тавилга эд хогшилд 200,0 сая төгрөг, бусад хөрөнгө 35,4 тэрбум төгрөгний хөрөнгө бүртгэгдсэн байна.

Тус байгууллагад ажлын хэсгийн хуваарийг урьдчилан хүргүүлсний дагуу 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдөр очиж ажиллахад тооллогын комисс ажлаа огт эхлүүлээгүй байсан тул Ерөнхий менежерийн 2016.05.18-ны өдрийн 01/875 дугаартай “Ажил эрчимжүүлэх” албан бичиг хүргүүлж, ажлыг эрчимжүүлсэн. Тооллогын ажлын явцад дараах ажлуудад зөвлөмж чиглэл өгч, биелэлт үр дүнг тооцож ажилласан: Үүнд:

- маягтуудад хавсаргах баримт бичгийг бүрэн бүрдүүлэх,
- хөрөнгийн ангиллын кодыг зөв сонгох
- барилга, байгууламж, тавилга эд хөрөнгө, тоног төхөөрөмж, машин тээврийн хэрэгслийн бүртгэлийг бүрэн, зөв хөтөлсөн эсэх,
- илтгэх хуудсанд маягт тус бүр дээр тодруулга, тайлбар бичих
- илүүдэлтэй ба ашиглалтгүй хөрөнгийг гүйцэд тодорхойлж бичих
- нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэлтэй тулган, бүртгэлгүй хөрөнгийг үнэлж, холбогдох маягтыг үйлдэх
- хөрөнгийг данснаас хасахад бүрдүүлдэг баримт материал болон эзэмшиж буй газрын кадастр, гэрээ, гэрчилгээг хавсаргах,
- маргаантай үндсэн хөрөнгийн бүртгэлийн хэрхэн үнэн зөв, бүрэн гүйцэд холбогдох хүснэгтэнд харуулах талаар заавар зөвлөгөө өгсөн болно.

Ажлын хэсгээс өгсөн удаа дараагийн зөвлөмж, чиглэлийг хангалтгүй хэрэгжүүлж, бүртгэл, маягтыг буруу, дутуу хөтлөх, баримтуудыг дутуу бүрдүүлэх, хавсаргах, зарим баримт мэдээлэл огт байхгүй байх, эд хөрөнгө, байгууламжийн нэршил, хэмжих нэгж, ангиллын код зэргийг буруу болон бүртгэлд сольж бүртгэсэн зэрэг алдаа дутагдлыг давтан гаргаж, үйл ажиллагаанд хүндрэл учруулж байсан ба удирдлагуудад тухай бүр танилцуулж ажиллалаа.

1.Барилга байгууламж.

Нийт 41 барилга байгууламжтайгаас 38 нь бүртгэлтэй, 3 нь бүртгэлгүй, мөн барилгын паспорт, хувийн хэрэг, баримтжуулсан фото зураг зэрэг үдсэн бичиг баримтууд огт байхгүй байсны зэрэгцээ “Барилга байгууламжийн бүртгэл” /Маягт 3/, “Барилга байгууламжийн хийц хэмжээсийн бүртгэл” /Маягт 3.1/-ийг огт хөтлөөгүй алдаа дутагдал байна.

Бүртгэлгүй 3 барилгад Цагаан давааны “Конторын барилга”, золбин нохой, муур устгах, шатаах зуухны өргөтгөлийн байр, гражууд бүртгэлгүй байна.

41 барилгыг газрын бичиг баримттай тулгахад газрын бичиг баримтгүй 12 барилга байгууламж байсан ба газрын байршлыг тодруулах асуудлаар зөвлөмж чиглэл өгсөн.

2.Автомашин.

Нийт 18,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 204 машин механизм бүртгэлтэй байна. Нийт машин техникээс 170 нь хэвийн ашиглагдаж байгаа бөгөөд 3,78 тэрбум төгрөгийн үнэ бүхий 38 техник балансаас хасуулах болон актлуулах асуудалтай байна. Үүнд дүүргүүдэд шилжсэн-34, бичиг баримтын зөрчилтэй-1, НМХГ-аас ашиглахыг хориглосон актлуулах-1, шатсан-1 /бульдозер/, эвдэрсэн-1 байна.

1-р баазад бүртгэлтэй машин техникүүдээс зам цэвэрлэгээний зориулалттай БНХАУ-д үйлдвэрлэсэн ISUZU маркийн 2 автомашин үндсэн зориулалтаараа ашиглах боломжгүй байгаа учраас зам цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал ачиж тээвэрлэх зориулалтаар өөрчлөх шаардлагатай байна. Мөн 2008 онд худалдан авсан АНУ-ын Sterling маркийн том мод сугалах зориулалттай 1 ширхэг машин одоог хүртэл ашиглагдаагүй байгаа тул уг машиныг ажиллуулж, хотын ногоон байгууламжид ургасан том модыг шилжүүлэн суулгах ажилд ашиглах шаардлагатай гэж үзэж байна.

Япон улсын буцалтгүй тусламжаар 2008 онд бэлэглэсэн хог тээврийн зориулалттай 31 автомашиныг дүүргүүдэд хуваарилан одоог хүртэл ашиглуулж байна. Мөн 2006 онд өвсний үндэс хөтөлбөрийн хүрээн Япон улсаас бэлэглэсэн 1997-1998 онд үйлдвэрлэгдсэн 6 автомашиныг дүүргүүдэд 2014 онд хуваарилсан. Дээрх автомашинууд нь одоог хүртэл НҮУБНэгтгэлийн баланст бүртгэлтэй байгаа тул дүүргүүдийн баланст шилжүүлэх шаардлагатай байна. Эдгээр автомашинуудыг тооллогын үеэр шалгах явцад хэд хэдэн машины гэрчилгээ солигдож, тухайн ашиглаж байгаа хог тээврийн байгууллагын нэр дээр гарсан байгаа нь /жишээ нь: ЧД-ийн ТҮК 1 машиныг өөрийн нэр дээр гэрчилгээ гаргуулсан/ НӨХГ-ын зөвшөөрөлгүйгээр гэрчилгээ солигдсон гэж үзэн зөрчилд тооцсон.

Иймд эдгээр автомашинуудыг НҮУБНэгтгэлийн баланст байгаа үнэ, элэгдлийн хэмжээгээр дүүргүүдийн баланст шилжүүлэн бүртгүүлж, гэрчилгээний зөрчилтэй байгаа автомашинуудын гэрчилгээг солиулах ажлыг НӨХГ-аас шуурхай арга хэмжээ авах шаардлагатай байна.

Улаанбаатар зам засвар арчлалт компаниас шилжиж ирсэн Сэлэнгэ аймгийн замын компаниас өр авлагадаа авсан гэх 16-06 СБА дугаартай Зил 130 машин нь /тус байгууллагад Гударнатор гэдэг нэрээр бүртгэгдсэн/ улсын бүртгэлд огт бүртгэгдээгүйн улмаас үзлэгт хамрагддаггүй, бичиг баримтын зөрчилтэй учраас ажилд гаргадаггүй 1 машин байна. Актлуулах асуудлаар НӨХГ-т хүсэлт гаргасан ба дуудлага худалдаанд удаа дараа орсон ч зарагдаагүй байна.

3.Далан суваг.

НҮУБН-ийн Зүүн салбарт 72089 м, баруун салбарт 63110 м, нийт 135199 м үерийн хамгаалалтын далан суваг бүртгэлтэй байна.

Бүртгэл маягтад тусгах явцад гарсан алдаа дутагдлыг залруулах, өөрчлөлт хөдөлгөөнийг хийх асуудлаар зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Бүртгэлд тусгагдаагүй далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугамны жагсаалтыг гаргуулж, бүртгэлжүүлэх шаардлагатай талаар зөвлөлөө. Борооны болон хөрсний ус зайлуулах шугамын 34, далан сувгийн дараах 3 буюу нийт 37 байршилд хөрөнгийн бүртгэл байхгүй байна. Үүнд:

- Хан уул дүүргийн Зайсангийн суваг-1900 м,
- Баянзүрх дүүргийн СЭМҮТ-ийн урд талын суваг-700 м,
- Сонгино хайрхан дүүргийн Баянгол нарангийн үерийн хамгаалалтын далан суваг-1070 м зэрэг болно.

Сонгино хайрхан дүүргийн 18 дугаар хорооны Драгон авто вокзалын 1100 м далан суваг нь 2002 оноос ашиглагдахгүй болсон бөгөөд, үерийн ус зайлуулах гаргалгаагүй, ус ордоггүй тул бүртгэлээс хасуулах шаардлагатай байна.

4.Буу:

Тус байгууллага нь буугүй гэж мэдээлж байсан боловч “Байгууллагад хамаарах нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл”-д 1ш, “Тавилга эд хогшил бусад үндсэн хөрөнгийн бүртгэлд 5, нийт 6 буу бүртгэгдсэн байв. Үүнд: 427,350 төгрөгийн үнэ бүхий ангийн буу 3ш, 450,000 төгрөгийн ТОЗ-8 маркийн буу 2ш, 160,000 төгрөгийн үнэ бүхий буу 1ш баруун салбарт бүртгэлтэй байна.

Анчдын 5ш бууг анчид нь өөрсдөө хувийн зардлаар авсан байх боловч цагдаагийн газраас галт зэвсэгт хяналт тавих үүднээс зайлшгүй байгууллагын бүртгэлд бүртгэгдсэн байх шаардлагатай гэсэн шаардлагын дагуу байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгагдсан байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ: НҮУБН ОНӨААТҮГ-т өгөх зөвлөмж:

1. Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу өмч хөрөнгийн бүртгэл мэдээллийг зааврын дагуу тооллогын маягтад зөв тусгах
2. Балансад тусгагдаагүй байгаа далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугамны жагсаалтыг гаргаж, хөрөнгөд бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх.
3. Газрын бичиг баримтгүй 12 барилга байгууламжийн газрын байршлыг тодруулах, хэрэв эзэмшлийн газартай бол газрын гэрчилгээ гаргуулах, бүртгэлжүүлэх.
4. Баянгол дүүргийн ТҮК-ээс ирсэн шатсан машины нөхцөл шалтгааныг тодруулах Ажлын хэсэг гаргаж, дүгнэлт гаргуулах, “Маргаантай эд хөрөнгийн жагсаалт” Маягт ТӨ11 маягтыг хөтөлж, НӨХГ-т хүргүүлэх.
5. Том шилжүүлэн суулгах зориулалттай автомашиныг ашиглалтанд ажиллуулах
6. Зам цэвэрлэгээний ISUZU маркийн 2 ширхэг автомашины зориулалтыг өөрчлөх ажлыг зохих журмын дагуу НӨХГ-т хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлэх.
7. Сэлэнгэ аймгаас өр авлагад авсан Гудирнатор нэрээр бүртгэгдсэн ЗИЛ маркийн машины бүртгэлийн асуудлыг шийдвэрлэж, ашиглах боломжгүй гэж үзвэл зохих журмын дагуу актлуулах
8. Осолд орсон, шатсан, дахин ашиглах боломжгүй болсон машин техникийг актлуулж, бүртгэлээс хасах, ослын шалтгааныг тодорхойлох, хохирлыг тооцох, актлах саналыг боловсруулах ажлын хэсэг яаралтай байгуулж ажиллах.
9. Дүүргүүдэд ашиглаж байгаа Япон улсын буцалтгүй тусламжаар олгосон нийт 37 машиныг балансаасаа хасуулах

НӨХГ-т хүргүүлэх санал:

1. Балансад тусгагдаагүй байгаа 3670 м далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах 42,023 м шугамыг үндсэн хөрөнгөд бүртгэх.
2. Сонгино хайрхан дүүргийн 18 дугаар хорооны Драгон авто вокзалын 1100 м далан сувгийг хөрөнгийн бүртгэлээс хасуулах.
3. Анчдын 5ш бууг үндсэн хөрөнгөөс хасуулах ажлыг зохион байгуулах.
4. Баянгол дүүргийн ТҮК-ээс ирсэн шатсан, ашиглалтын хэрэгцээ шаардлага хангахгүй болсон 2ш машиныг актлах асуудлыг шийдвэрлэх.
5. Улсын бүртгэлгүй, бичиг баримтгүй 16-06 СБА Зил 130 машиныг актлах асуудлыг шийдвэрлэх.

6. Зам цэвэрлэгээний ISUZU маркийн 2 ширхэг автомашины зориулалтыг өөрчлөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.
7. Дүүргүүдэд ашиглаж байгаа Япон улсын буцалтгүй тусламжаар олгосон нийт 37 машиныг НҮУБНэгтгэлийн балансаас хасч, дүүргүүдийн баланст шилжүүлэх арга хэмжээ авах

ХЯНАЖ ТАНИЛЦСАН:
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: Ц.РЭГЗЭДМАА

ТАНИЛЦСАН:
КОМИССИЙН ГИШҮҮН: Б.ЭРДЭНЭБАТ
Л.АЛТАНГЭРЭЛ
Б.ОЮУНСҮРЭН
Бя.ЭРДЭНЭБАТ
С.АРИГУУН
З.МӨНГӨНЗУЛ
Д.БУЛГАН
Т.ОЮУНТӨГС

БОЛОВСРУУЛСАН:
ҮАМХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН: АЖЛЫН ХЭСГИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Б.ГЭРЭЛ